

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН
2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2021.03.15

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль, ГХЯ-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү, худалдан авалтын журам, заавар, төлөвлөгөө, тайлан болон бусад мэдээ, мэдээллүүдийг ГХЯ-ны цахим хуудас /www.mfa.gov.mn/-нд нээлттэй байрлуулж, ил тод байдлыг ханган ажиллаж байна.	90%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Яамны газар, нэгжийн удирдлага болон албан хаагчидтай холбоо барих мэдээлэл буюу газрын үндсэн чиг үүрэг, албан хаагчдын өрөөний утасны дугаар, хариуцах ажлын талаарх хүснэгтийг боловсруулж, яамны цахим хуудсанд байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Иргэдэд үзүүлэх консулын үйлчилгээний төлбөр, хураамжийн талаарх мэдээлэл, www.consul.mn сайтад тодорхой оруулсан. ДТГ-уудаас Консулын газарт цахим шуудангаар илгээж буй итгэмжлэлийн бүртгэл, эмх цэгц, хайлтыг сайжруулах, хялбаршуулах, иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх үүднээс 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс	100%

		эхлэн цахимаар шалгах боломжийг www.consul.mn вэб хуудаст нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн төлбөр тооцооны үйлчилгээг хөнгөвчлөх үүднээс ГХЯ, КГ-т "Гэрэгэ киоск" банкны мөнгө шилжүүлэх машин ашиглаж байна. ГХЯ-ны Консулын газрын үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар амралтын өдөр, цаг харгалзахгүйгээр үүрэн болон суурин холбооны бүх хэрэглэгчдэд мэдээлэл өгөх шуурхай утасыг ажлуулж байна.	
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Авлигын эсрэг НҮБ-ын конвенци, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль, "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай" УИХ-ын Байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоол, уг тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах болон хавсралтыг шинэчлэн батлах тухай УИХ-ын Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын тухай талаарх зэрэг АТГ-аас ирүүлсэн мэдээлэл, зөвлөмж, сургалтын материал, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан Гарын авлага зэргийг яамны цахим хуудсанд байршуулсан.	90%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Монгол Улсын Төрийн гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг олон нийтийн цахим сүлжээгээр зохион байгуулах зорилгоор хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалыг яамны цахим хуудсанд байршуулж төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтдийн санал авч төсөлд тусгасан. Мөн Дэлхийн Монголчууд, Монгол Улсыг гадаадад сурталчлах Үндэсний хөтөлбөрүүд 2020 онд хэрэгжиж дуусахтай холбогдуулан "Дэлхийн Монголчууд II", "Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээний төсөл боловсруулан яамны газар, нэгж, ДТГ-уудаас санал авч, ойрын үед төрийн байгууллага болон эрдэмтэн, шинжээчдийн санал авахаар ажиллаж байна.	100%

6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	<p>"E-Mongolia" платформоор дамжуулан иргэдэд одоогоор үзүүлж буй үйлчилгээнээс хилийн чанадад байгаа Монгол иргэдэд 37 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг олгох үйлчилгээг эхний ээлжинд хамруулах, ингэхдээ E-mongolia цахим хуудасны нүүр хуудаст байгаа "Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гадаад иргэн" гэсэн хэсэгт хилийн чанадад байгаа Монгол иргэдэд чиглэсэн "гадаадад байгаа монгол иргэн" гэсэн шинэ цэс нээж, дээрх 37 үйлчилгээний холбоосыг байршуулах саналыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлээд байна.</p> <p>Түүнчлэн "E-Mongolia" цонхоор дамжуулан төрийн үйлчилгээг гадаадад байгаа иргэдэд хүргэх ажлын хүрээнд монгол иргэдэд тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг хялбаршуулах, иргэдийг тоон гарын үсэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар хамтран ажиллахаар тогтсон болно.</p> <p>Консулын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэдийн цаг завьг хэмнэх зорилгоор, ГХЯ-ны Консулын газарт баталгаажуулсан баримт бичиг, тухайлбал Апостиль гэрчилгээ, консулын баталгаажуулалт хийсэн баримт бичгийг, иргэний хүсэлтийн дагуу Улаанбаатар хот дотор хаягаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх шуудангийн үйлчилгээ нэвтрүүлэх асуудлаар холбогдох танилцуулаг судалгаа хийн ажиллаж байна.</p>	90%
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	<p>Тайлбар: Хуулийн энэхүү заалтын дагуу ГХЯ-ны гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын шаардлага гараагүй болно.</p>	
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим	<p>Тайлбар: Тус байгууллагаас тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.</p>	

	хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn болон www.shilendans.gov.mn цахим системүүдэд тухай бүр ил тод мэдээлж байна. 2020 онд "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-д улсын төсвөөс 224,0 сая төгрөг төсөвлөгдсөн ба иргэдэд туслах сангийн зарцуулалтын тайланг http://consul.mn/index.php?moduls=6 цахим хуудсанд байршуулав.	90%
Хэсгийн дундаж хувь:		94.2%	
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	2020 онд удирдах албан тушаалтны 5 сул орон тоо /ГНБД, 4 газрын захирлын/-г нээлттэй зарлаж, энэ тухай нийт албан хаагчдад мэдээлэн, Төрийн албаны зөвлөлөөс зохих журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ирүүлсэн шийдвэрийн дагуу томилгоог хийж албажуулсан.	90%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", 2019 оны 272 дугаар тогтоолоор баталсан "Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм"-үүдийг яамны цахим хуудсанд байршуулсан.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Гадаад хэргийн сайдын 2015 оны А/63 тоот тушаалын хавсралтаар баталсан "Дипломат албаны хүний нөөцийн бодлого"-ыг яамны цахим хуудсанд байршуулсан.	100%

4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх салбар зөвлөлийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө зэргийг яамны цахим хуудсанд байршуулав. Дипломат албанд орох иргэдээс шалгалт авах журмын төслийн талаар Төрийн албаны зөвлөлтэй зөвшилцөн, дипломат албаны тухай хуульд заасан болзол, шалгуурыг Гадаад харилцааны сайдаар батлуулж ТАЗ-д хүргүүлсэн. Мөн яам, ДТГ-т ажиллах төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 165 дугаар тогтоолоор, 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 35 дугаар тогтоол, 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 82 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.	90%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Яамны 13 газар, нэгж, хилийн чанад дахь 46 ДТГ-т ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг нэгтгэх ажлыг зохион байгуулж яамны удирдлагад танилцуулсан. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх тухай Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр онлайн сургалтад холбогдох газрын төлөөллийг оролцуулсан. Журмуудыг яамны газар, нэгж, хилийн чанад дахь бүх ДТГ-уудад 2020 оны 12 дугаар сард цахимаар хүргүүлсэн.	90%
Хэсгийн дундаж хувь:		94%	
Хэрэгжилтийн дундаж хувь:		94.1 %	